



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 4/157

Номгон

Аймгийн шинжлэх ухаан, технологи,
инновацийн дэд зөвлөл байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.3, Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүс, орон нутагт шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх зорилт, үйл ажиллагааг шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий дэд зөвлөлийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Боловсролын газрын дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Соёл урлаг, аялал жуулчлал, залуучууд хөгжлийн газрын дарга

Баянхонгор аймаг дахь Политехникийн коллежийн захирал

Баянхонгор аймаг дахь Өлзийт мэргэжлийн боловсролын сургуулийн захирал

Нарийн бичгийн дарга

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

2.Орон нутагт шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх зорилго, зорилт, арга хэмжээний төслийг боловсруулан бодлогын баримт бичгүүдэд тусгуулах, уялдуулах, хамтын ажиллагааг хөгжүүлж ажиллахыг гишүүдэд, Бүс, орон нутгийн шинжлэх ухаан, технологи, инновацыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг


626010404

хангаж, дэд зөвлөлийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг /Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого төлөвлөлтийн хэлтэст тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

4.Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/212 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ